

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 04 (ТОЙМ)

Төрийн албаны зөвлөлийн хуралдаан 2011 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 14 цаг 30 минутанд Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөөнд болж, нийт 00 цаг 50 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүн, уг албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 9-ийн “а”, 32, 34, 39 дүгээр зүйлийг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад орж тэнцсэн дор нэр дурдсан иргэдийг Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэх:</p> <ol style="list-style-type: none">1/Давагсүмбэрэлийн Гончигсүрэн,2/Дондогийн Жаргалсайхан,3/Жунайн Мөнхжаргал,4/Дондонхүүгийн Отгонбаатар,5/Лхамжавын Хандсүрэн,6/Цамбаллэгшидийн Энхбаяр,7/Сүхээгийн Эрдэнэтуяа. <p>2. Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Дондогийн Жаргалсайханыг тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын хувьд хангаж байгааг нь харгалзан Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд</p>

		<p>томилуулахаар нэр дэвшүүлэн дүгнэлт гаргаж Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Хүрэлбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>1992-1996 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байсан Ж.Батсуурийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1990-1992 онд БНМАУ-ын Үндэсний хөгжлийн сайдаар томилогдон, 1992-1996 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон, 1999-2000 онд Монгол Улсын Ерөнхий сайдын Нийгмийн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байсан Жамъянгийн Батсуурийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын албан тушаалд томилогдох ажилтныг нийтэд нээлттэй сонгон шалгаруулах тухай</p>	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг сонгон шалгаруулах тухай зарыг нийтэд нээлттэй зарлахаар болов.</p>
4	<p>2011 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Засгийн газрын агентлаг Төрийн өмчийн хороо, Мал эмнэлэг, үржлийн газар, Биеийн тамир, спортын газрын сул орон тоог нөхөхөөр зохион байгуулагдсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 55 дугаар зүйлийг баримталж, 2011 оны 02 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.2011 оны 02 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 13 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах,</p> <p>2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн</p>

		<p>жагсаалт"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 7 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 2 дугаар хавсралтаар батлах,</p> <p>3.Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 7 иргэнийг тухайн албан тушаалд томилохыг тус тусын томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох,</p> <p>4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

---oOo---